



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/21

Мандалговь

“Гэр бүл, хосын видео ярилцлага”
зохион байгуулах тухай

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 28 дугаар зүйл, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 2018-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.55 дах заалт, Дундговь аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны үндсэн чиглэлийн 2.3.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төсвийн шууд захирагчаас Төрийн жинхэнэ албан хаагчтай байгуулсан 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүлийн гишүүдийн тэгш эрх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, харилцааны тогтвортой байдлыг дэмжих, иргэд олон нийтэд гэр бүлийн боловсрол олгох зорилгоор “Гэр бүл, хосын видео ярилцлага”-ыг 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр хүртэл зохион байгуулсугай.

2. “Гэр бүл, хосын видео ярилцлага” зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, хөтөлбөрийг 2 дугаар, шаардагдах төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 500.000 (Таван зуун мянга) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бүжинлхам)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бүжинлхам), гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

431190043

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны 25 дугаар сарын 15-ны өдрийн
А/Б/ дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



“ГЭР БҮЛ, ХОСЫН ВИДЕО ЯРИЛЦЛАГА”
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Бүжинлхам

Гишүүд:

Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн


Г.Отгонсүрэн

Хамгаалах байрны арга зүй, сэтгэл зүйч

Т.Насандэлгэр

Залуучуудын хөгжлийн төвийн сургалт хариуцсан
ажилтан


Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны 25 дугаар сарын 15-ны өдрийн
11.21 дугаар тушаалын 2 дүгээр хавсралт



"ГЭР БҮЛ, ХОСЫН ВИДЕО ЯРИЛЦЛАГА"-ЫН ХӨТӨЛБӨР

№	Сэдэв	Оролцох зочин	Хугацаа	Хариуцах эзэн
1	Эхнэр, нөхрийн зан чанарын ялгаа, сэтгэл зүйн онцлог	Гэр бүл судлаач Ж.Баясгалан	2021.03.17	Г.Отгонсүрэн Б.Бүжинлхам
2	Гэр бүлийн үнэ цэнэ	Гэр бүл судлаач Ж.Баясгалан	2021.03.24	Г.Отгонсүрэн Б.Бүжинлхам
3	Аавын хайр ба ирээдүйн нөхөр	Сэтгэл зүйч А.Тэгшбаяр	2021.03.31	Г.Отгонсүрэн Б.Бүжинлхам
4	Гэр бүл дэх мөнгөний асуудал	Сэтгэл зүйч А.Тэгшжаргал	2021.04.07	Г.Отгонсүрэн Б.Бүжинлхам

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн
11/21 дугаар тушаалын 3 дүгээр хавсралт



“ГЭР БҮЛ, ХОСЫН ВИДЕО ЯРИЛЦЛАГА”-Д
ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Оролцогч зочин	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Лектор Ж.Баясгалан	2 цаг	150.000	300.000
2	Лектор А.Тэгшжаргал	2 цаг	100.000	200.000
Нийт				500.000

----oOo----